



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖ БА ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХУЧИРХИЙЛЭЛ

Редакциудад зориулсан практик зөвлөмж, удирдамж

АГУУЛГА

Редакци, сэтгүүлчийг дэмжинэ.....	2
Удиртгал. Жендэрийн тэгш байдлыг хангахад хэвлэл мэдээлэл яагаад чухал үүрэгтэй вэ?.....	3
1. Жендэрийн мэдрэмжтэй нийтлэл, нэвтрүүлгийн бодлогын удирдамж	7
2. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар нийтэлж, нэвтрүүлэхэд баримтлах зарчим.....	12

РЕДАКЦИ, СЭТГҮҮЛЧИЙГ ДЭМЖИНЭ

2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар баталсан Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хянах, олон нийтэд ойлгуулахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл онцгой чухал үүрэгтэй билээ. Энэхүү “Тогтвортой хөгжлийн 17 зорилт”-ын тавдугаарт жендэрийн эрх тэгш байдлыг хангахаар заасан байдаг. 2014 онд Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага /ЮНЕСКО/, Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоотой хамтран “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-үүдийг гаргасан.

Ийнхүү олон улсын сэтгүүл зүйн түвшинд жендэрийн тэгш байдлын асуудалд онцгой анхаарал хандуулж, “жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй” хэмээх ойлголтыг сэтгүүл зүйн агуулгын чанар, чансаа, мэргэжлийн мэдлэг, ур чадвартай шууд холбон үзэж байна. Тухайлбал сэтгүүл зүйн нэгж бүтээл дэх жендэрийн мэдрэмжийн асуудал нь бичсэн сэтгүүлчийн ур чадвар төдийгүй тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээг тодорхойлж, улмаар түүний нэр хүнд, итгэл үнэмшлийн асуудал болж байна.

Тиймээс орчин үеийн хэвлэл мэдээллийн байгууллагын мэргэжлийн түвшин, дүр төрх, нэр хүндээ бэхжүүлэхэд тань тус болох үүднээс хэвлэл мэдээллийн ажилтан, уран бүтээлч, удирдлагад хандаж Сэтгүүл зүйн бүтээлийн чанарыг агуулгын талаас нь нягтлан шалгах дараах удирдамжийг Танай редакцид хүргүүлж байгааг хүлээн авна уу. Эдгээр нь танай хамт олны өдөр тутмын ажилд тус нэмэр болно гэдэгт итгэлтэй байна.

Жич: 1-р хэсэгт Жендэрийн мэдрэмжтэй нийтлэл, нэвтрүүлгийн бодлогын удирдамж, 2-р хэсэгт Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар нийтэлж, нэвтрүүлэхэд баримтлах зарчмыг хавсаргав.

Танд болон танай хамт олонд амжилт хүсье
Монголын Хэвлэлийн Хүрээлэн

УДИРТГАЛ

Жендэрийн тэгш байдлыг хангахад хэвлэл мэдээлэл яагаад чухал үүрэгтэй вэ?

Хувь хүн бүрийн өөрөөс нь салгаж үл болох эрхэм чанар буюу үнэ цэнийг ойлгон үнэлж, тэдний олон талт, олон ургальч үзэл санааг нийтлэлийн бодлогод харгалзан тусгаснаар сэтгүүл зүйд итгэх олон нийтийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлнэ. Улмаар хэрэглэгчид болох уншигч, үзэгч, сонсогчдын хүний эрх, жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, нийгэм дэх хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчилнө.

Суурь үндэслэлүүд:

- Хүн бүр арьсны өнгө, яс үндэс, нас, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа болон нийгмийн гарал үүсэл, нийгэмд эзлэх байр суурь, өмч хөрөнгө, орлогын байдал зэргээс үл хамааран аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байж, эрхээ эдлэх ёстой **/Олон улсын гэрээ, конвенц/**
- Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байдаг бөгөөд Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, хүйсийн ялгааг эс харгалзан, ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой **/Хүний эрхийн түгээмэл тунхаглал/**
- Жендэрийн тэгш байдлыг хангах нь нийгмийн хөгжил дэвшилд түлхэц болж, шударга бус байдал, түүний дотор аливаа ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтыг арилгах арга зам, нийгэмд, хүн амын тодорхой бүлэгт чиглэсэн аливаа хөгжлийн үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй, оновчтой болгох зайлшгүй нөхцөл юм **/НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага/**

- Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын болон гэр бүлийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглоно /**Монгол улсын жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль**/

- Хэн ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар ялгаварлан гадуурхалтын золиос болгох ёсгүй /**Монголын хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим**/

Үндсэн нэр томъёоны тайлбарууд¹:

- **Жендэр** гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн биологийн ба нийгмийн үүргийг ялган салгаж ойлгохын тулд хэрэглэх болсон нэр томъёо. Тодруулбал, хүмүүсийн хүлээсэн үүрэг, хариуцлага, тулгарч буй саад бэрхшээл, хүртэж буй боломж бололцоог нь дүгнэн шинжлэх нийгэм-эдийн засаг, улс төрийн шинжтэй хувьсах хэмжигдэхүүн бөгөөд нийгмийн анги давхраа, нас, арьс өнгө /яс үндэс, шашин шүтлэг, газар зүй, эдийн засаг, улс төр, соёлын орчин гэхчлэн олон үзүүлэлттэй харилцан хамааралтай байдаг. Жендэр нь нөгөө талаас биологийн хүйс бүрт хамааруулан ойлгож хэвшсэн нийгмийн хүлээлт, хэм хэмжээ, итгэл үнэмшил, хандлагыг илэрхийлдэг.

- **Жендэрийн хэвшмэл ойлголт** (стереотип) нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс, тодорхой бүлгүүдийн шинж төрх, ялгаа, гүйцэтгэх үүргийн тухайд нийгэм соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан ерөнхий ойлголт. Жендэрийн хэвшмэл ойлголт нийгэм соёл бүрт харилцан адилгүйгээс гадна цаг хугацааны явцад өөрчлөгддөг боловч эмэгтэйчүүдийн захирагдмал, хамааралтай байр суурийг хадгалж бэхжүүлсэн түгээмэл шинжтэй байдаг. Энэхүү жендэрийн хэвшмэл ойлголт нь шударга бус хандахын, аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг.

¹ Жендэрийн Үндэсний Хороо. Жендэр ба бодлого төлөвлөлт. 2018

- **Жендэрийн тэгш байдал** нь тухайн нийгэмд тодорхой үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн, боломж, нөөц, урамшууллыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эдлэх ба хүртэх боломжтой байх тухай ойлголт. Гэхдээ орчин цагт жендэрийн тэгш байдлыг эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай хандах бус, харин нөхцөл байдал, боломжийг нь адил тэгш болгоход анхаарах явдал гэж ойлгох болсон. Өөрөөр хэлбэл энэ нь эрэгтэй эмэгтэй хүмүүс биологийн хувьд өөр өөрийн онцлогтой ч тэдний эдлэх боломж бололцоо нь тэгш, нийгэм, гэр бүлдээ эзлэх байр суурь, эрх үүрэг нь адил байх тухай ойлголт юм.
- **Жендэрийн мэдрэмж** нь эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадвар юм. Ялгаварлан гадуурхахгүй байх нь тэгш байдлын үзэл баримтлалтай салшгүй холбоотой.
- **Жендэрийн ялгаварлан гадуурхалт** гэж эрэгтэй, эмэгтэй хүмүүс улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон бусад салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх, хэрэгжүүлэхэд нь хүйсээр нь ялган хязгаарлах буюу үгүйсгэхийг хэлнэ. Жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт нь жендэрт суурилсан хүчирхийлэлд нөлөөлөгч хүчин зүйлсийн нэг.
- **Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)** нь өөрийн эрх мэдэл хүчний давуу байдлаа ашиглан хэн нэгний хүсэл зоригийн эсрэг үйлдэгддэг хүчирхийлэл бөгөөд охид эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтын түгээмэл хэлбэр юм. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь бусдыг хянах, эрх мэдлээ мэдрэхийн тулд хэн нэгнийг үгүйсгэх, хязгаарлах, хянах, дарамт шахалт үзүүлэх, заналхийлэх, зовиур шаналал, хор хохирол учруулах буюу учруулж болзошгүй санаатай үйлдэл, эс үйлдэл юм.

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд тэгш бус байдлыг бий болгоод зогсохгүй хохирогчийн эрүүл мэнд, хараат бус, бие даасан байдал, аюулгүй байдалд хохирол учруулдаг. ЖСХ нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахтай нягт холбоотой ойлголт юм.

- **ЖСХ-ийн төрлүүд:** Гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ) нь **эрх мэдлийн тэгш бус** харилцаан дээр суурилан санаатай үйлдэгддэг. Хүчирхийллийн харилцаа нь тодорхой үе шатууд бүхий давтамжтай байдгаас хохирогч нь хүчирхийллийн давтамж, үр дагавараас шалтгаалан хүчирхийллийн эргүүлэгт ордог. Энэ нь даамжрах тутамд амь насаа алдах хүртэл эрсдэлд хүргэдэг аюултай. ГБХ нь гэр бүлийн гишүүн болон хамаарал бүхий хүний зүгээс бусаддаа хяналт тогтоон хамааралд оруулж буй үйлдэл, эс үйлдэл юм.
- **Хүн худалдаалах гэмт хэрэг** нь эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийг худалдах, тэднийг садар самуун явдалд ашиглан мөлжих бүх хэлбэрийн үйлдэл. Хүн худалдаалах гэмт хэргийг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нэг бие даасан төрөл гэж үздэг.
- **Бэлгийн дарамт, хүчирхийлэл** нь хүний нэр төр, бие махбод, эрүүл мэндийн байдалд сөргөөр нөлөөлдөг ЖСХ-ийн нэг хэлбэр юм. Бэлгийн хүчирхийлэл нь хэн нэгнийг хүсээгүй, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хууран мэхэлж, айлган сүрдүүлж, хүч хэрэглэн өөрийн эрх мэдэл, бэлгийн дур хүслээ тулган хүлээлгэдэг. Ажлын байран дахь бэлгийн дарамт (АББД) нь хохирогчийн ажил эрхлэх боломжийг хязгаарлаж, шударга бус байдалд оруулдаг. Бэлгийн хүчирхийллийн хохирогчдын дийлэнх хувь нь эмэгтэйчүүд, охид ба сүүлийн үед хөвгүүд ч хохирогч болох явдал ихсэж байна.

1. ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ НИЙТЛЭЛ, НЭВТРҮҮЛГИЙН БОДЛОГЫН УДИРДАМЖ

Нийтлэл, нэвтрүүлгийн бодлогын цар хүрээ, чанарыг тодорхойлох шалгуурууд

- ✓ Нийтлэл, нэвтрүүлгүүд нь бүхэлдээ эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг цогц бөгөөд бодитой байр сууринаас харж, тэдний оролцоо бүхий үйл ажиллагааг бүрэн тусгасан эсэх;
- ✓ Нийгэм дэх байр сууринаас хамааралтай зарим тодорхой сэдэв, чиглэлийн нийтлэлд эмэгтэйчүүд эсвэл эрэгтэйчүүд үл үзэгдэх байдалтай байгаа эсэх;
- ✓ Нийтлэлүүд нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст дуу хоолойгоо илэрхийлэхэд шударга хандаж, адил тэнцүү зай талбай / хугацаа олгосон эсэх;
- ✓ Жендэрийн асуудлууд, нийгмийн давхарга, арьс өнгөний үзэл зэрэг тодорхой сэдвээр сэтгүүлч, редакторууд ижил ойлголттой байгаа эсэх, эдгээр асуудлуудаар мэргэшсэн иргэний нийгмийн байгууллага, мэргэжилтэнтэй хамтарч ажиллаж, мэргэжлийн зөвөлгөө авдаг эсэх;
- ✓ Бүтээлдээ дүн шинжилгээ хийж, сэдэв, үйл явдлын цаана орших жендэрийн асуудлыг ухаж гаргаж чадсан эсэх, тал бүрийн үзэл бодол, эх сурвалжуудыг зөв чиглүүлж чаддаг эсэх;
- ✓ Орчин, байрлалыг зөв тодорхойлж сонгосон эсэх: сонины нүүрийн аль хэсэг эсвэл хөтөлбөрийн хаана тухайн бүтээл байрласан, ийнхүү байрлуулсан нь тухайн мэдээний ач холбогдлын талаарх төсөөлөл бий болгож буй эсэх, эргэн тойронд нь ямар материалууд байрлуулсныг анхаарах.

Жендэрийн мэдрэмжтэй бичих зарчим ба аргууд

Ерөнхий зарчмууд:

- ✓ Аливаа бичвэрт хүйсийн тэнцвэрийг хадгалах, аль ч хүйст шударга хандах. Шударга хандах гэдэг нь ижилхэн боломж олгохыг хэлнэ. Тодорхой сэдвийн мэдээнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль нэг нь эх сурвалжийн хувьд давамгайлаагүй байх. Зарим төрлийн ялангуяа улс төр, бизнесийн мэдээлэлд эмэгтэйчүүдийг огт харуулахгүй хэрнээ гэмт хэргийн мэдээлэлд хохирогч, нийгмийн сэдэвтэй мэдээлэлд өөрийгөө золиосолсон эхнэр, ээж талаас нь харуулаад эхэлдэгийг анхаарах. Улс төрийн асуудлаар эмэгтэй хүн ч санаа оноогоо хэлж чаддаг. Спортод эмэгтэйчүүд ч амжилт гаргадаг гэдгийг байнга санах.
- ✓ Гарчиг, график, зураг, дуу, дүрс бичлэгт жендэрийн асуудлыг хялбаршуулж гаргахгүй байх. Товчилсон хэлбэрээр хялбаршуулсан мэдээллийг богино хугацаанд олон нийтэд өгөх гэж оролдох нь тэдний дунд аль хэдийн бий болсон хэвшмэл ойлголтыг баталгаажуулдаг. Радио, телевизүүд уйлж буй эмэгтэйн дүрсийг гаргадаг хэрнээ уг эмэгтэйгээс юу ч асуудаггүй, яриулдаггүй тохиолдол олон. Энэ нь гол асуудлаас хүмүүсийг холдуулдаг. Сэтгүүл зүйн үнэн, бодит зарчмыг хангахын тулд гарчиг нь агуулгаа илэрхийлсэн, гэрэл зураг, график, дүрс бичлэг нь агуулгатайгаа тохирсон байх шаардлагатай. Гэрэл зураг бүрийн дор тайлбар, гэрэл зурагчны нэрийг бичих ёстой.

Агуулгад хүйсийн тэгш байдлыг хадгалах аргууд:

- ✓ Ярилцлага авах үед зарим эмэгтэйчүүд ичиж, эмээх хандлагатай байдаг ч, бичих гэж байгаа зүйл болон түүний үг ямар чухал болохыг тайлбарлавал тэд ойлгоно. Тэдэнтэй ойлголцож чадвал дараа дараагийн хэвлэл мэдээллийн асуулт, ярилцлагаас тэд ичиж эмээхгүй болно.

- ✓ Нийгэмд зөвхөн эрэгтэйчүүд амжилт гаргадаггүй. Эмэгтэйчүүд ч бас улс төр, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, спортод амжилт гаргадаг. Эмэгтэй хүмүүсийн амжилтад эрэгтэйчүүдийнхтэй адил ач холбогдол өгөх боломжтой.
- ✓ Хүүхдээ асарч, гэрээ цэвэрлэж, хоол хийдэг эрэгтэйчүүд, эсвэл зөвхөн эрэгтэйчүүдийн л голлон ажилладаг салбарт ажил хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүд гэх мэт уламжлалт бус үүрэг гүйцэтгэж байгаа талаас аль аль хүйсийг хэвлэл мэдээллээр харуулахыг эрмэлзэх.
- ✓ Эмэгтэйчүүдийг олон талт дүрээр харуулах. Эмэгтэйчүүдийн дунд боловсролгүй хүн ч бий, эрдэмтэн ч бий, албан тушаалтан ч бий, ажилчин ч бий, ядуу хүн ч бий, баян хүн ч бий, улс төрч ч бий, нийгмийн идэвхтэн ч бий. Аль нь ч бай тэр дүрээрээ хэвлэл мэдээлэлд гарах ёстой.
- ✓ Эмэгтэйчүүдийг миссийн тэмцээнд оролцогч, загвар өмсөгч, дуучин, жүжигчин, эсвэл тэднийг гэр бүлд эзлэх байр суурь, нөхөн үржихүйн үүргээр нь болон сексийн хэрэглүүр, хохирогч гэсэн утгаар их харуулдаг. Эдгээр ойлголтыг эвдэж нийгэмд ажил хөдөлмөр эрхэлдэг, алсын зорилго чиглэлтэй нийгмийн идэвхтэй гишүүн, шийдвэр гаргахад оролцогч талаас нь харуулж чадвал жендэрийн хэвшмэл ойлголтыг эвдсэн агуулга болно.

Нэгж бүтээл /мэдээ, сурвалжлага, ярилцлага, хөрөг, асуудал хөндсөн өгүүлэл, нэвтрүүлэг/-ийн агуулгыг нягтлах шалгуурууд

Гарчиг:

- ✓ Гарчиг нь мэдээний гол агуулга, санааг үнэн зөвөөр тусгасан уу?
- ✓ Хүйсийн талаарх хэвшмэл ойлголт / төсөөллийг агуулсан уу?
- ✓ Энэхүү хэвшмэл ойлголт / төсөөлөл нь мэдээний агуулгад шууд хамааралтай юу?

Мэдээний өнцөг ба чиглэл:

- ✓ Мэдээний сэдэвт эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил тэгш эрхтэй байдлаар туссан байна уу?
- ✓ Энэ мэдээ нь хүйсийн талаарх тогтсон хэвшмэл ойлголт / төсөөллийг бататгасан уу, өөрөөр хэлбэл үүнийг ил, далд байдлаар дэмжсэн байна уу?
- ✓ Мэдээ нь тогтсон хэвшмэл ойлголт / төсөөллийг үгүйсгэх хандлагатай байна уу?
- ✓ Мэдээ нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн талаар ямар сэтгэгдэл төрүүлж, ямар дүр зургийг харуулж байна вэ?
- ✓ Асуудалд хүний эрхийн байр сууринаас хандсан уу?

Эх сурвалж:

- ✓ Аль нэг эх сурвалжийн найдвартай байдалд эргэлзээ төрөхөөр байна уу?

Хэл найруулга:

- ✓ Хүйсээр илт ялгаварласан үг хэллэг ашигласан уу?
- ✓ Ашиглаж буй тэмдэг нэр нь тухайн сэдэвт хамааралтай бөгөөд бодитой байна уу?
- ✓ Эсвэл нэг талын өрөөсгөл хандлага, хэвшмэл ойлголт / төсөөллийг дамжуулж байна уу?
- ✓ Эмэгтэй, эрэгтэй хүнийг дүрсэлсэн, ялангуяа бие бялдар эсвэл сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн үг хэллэгийн хооронд ялгаа байна уу?
- ✓ Дээрх дүрслэлүүд нь мэдээний гол агуулгад шууд хамаатай эсэх?

- ✓ Хэвшмэл ойлголт / төсөөллийг дэмжсэн хэлц үг, хэллэг ашигласан байна уу?

Дүрс:

- ✓ Дүрсүүд (видео, гэрэл зураг болон гар зураг) мэдээний агуулгыг үнэн зөвөөр тодотгосон байна уу?
- ✓ Эсвэл дүрсүүд (видео, гэрэл зураг болон гар зураг) нь тогтсон хэвшмэл ойлголт / төсөөллийг л дамжуулж байна уу?
- ✓ Дүрс нь бие бялдар (ялангуяа хүйсийн ялгааны талаас)-ыг тодотгож буюу илүү дөвийлгөж харуулж байна уу?
- ✓ Дүрс нь эмэгтэй болон эрэгтэй хүний нэр хүндэд халтай байна уу?
- ✓ Дүрс нь мэдээнд хамааралтай юу?
- ✓ Өөр дүрс байвал илүү тохирох байсан уу?
- ✓ Дүрс нь эмэгтэй хүнийг хүчирхийлэлд өртөгч эсвэл хохирогч байдлаар харуулж байна уу?
- ✓ Дүрс нь идэвхтэй, эрч хүчтэй эмэгтэй хүнийг харуулж байна уу?
- ✓ Дүрс нь идэвхгүй, сул дорой эмэгтэй хүнийг харуулж байна уу?
- ✓ Мэдээний агуулгын хүрээнд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дүрсээр дамжуулан хүргэж буй ерөнхий санаа юу вэ?

2. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААР НИЙТЭЛЖ, НЭВТРҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Иргэдийн хувьд төдийгүй сэтгүүлчдийн дунд байдаг **Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх** түгээмэл буруу ойлголтыг залруулах. Эдгээрт:

- ✓ **Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-д тодорхой төрлийн хүмүүс л өртдөг:** ЖСХ-д хэн ч өртөж болно. Статистик үзүүлэлтээс харахад ЖСХ-д өртөх нь боловсрол, шашин, нийгмийн анги, давхаргаас хамаарахгүй, нийгмийн бүх түвшинд түгээмэл байна. ЖСХ-д өртөгсдийн талаарх сөрөг хэвшмэл ойлголт нь хүчирхийллийн асуудлыг зөв ойлгож, хохирогсдод туслалцаа үзүүлэхэд хүндрэл учруулж байна.
- ✓ **Бэлгийн хүчирхийллийг голдуу танихгүй хүмүүс үйлддэг:** Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар гурван эмэгтэй тутмын нэг нь найз, нөхөр, хамтрагчийн хүчирхийлэлд өртсөн байна. Бэлгийн хүчирхийллийн 70 хувь нь ойрын хүрээлэлд, нэн ялангуяа хамтран амьдарч буй хүнтэй холбоотой байдаг аж.
- ✓ **Хүчирхийлэл үйлдэгч үргэлж “өвчтэй” эсвэл “гэмт хэрэгтэн”, “бүтэлгүй амьтан” байдаг:** Гэтэл хүчирхийлэгч хаа сайгүй байдаг. Үүнийг ойлгож, хүлээн зөвшөөрөөгүй нөхцөлд жирийн гэр бүлийн эр нөхөр, эсвэл нийгэмд нөлөө бүхий хэн нэгний үйлдсэн хүчирхийллийн тухай мэдээлэлд нийгэм итгэдэггүй.

- ✓ **Эмэгтэйчүүд хувцаслалтаасаа болж ЖСХ-д өртдөг:** Хүчирхийлэгч үйлдлээ зөвтгөхийн тулд хохирогчийг буруутгах хандлагатай байдаг. Ингэж өөрийгөө зөвтгөх нь хүчирхийллийн нэг хэлбэр бөгөөд анхаарлыг хүчирхийлэгчээс холдуулдаг. Хүчирхийлэгч үйлдлийнхээ төлөө бүрэн хариуцлага хүлээх ёстой. Сэтгүүлчид үүнийг шаардаж, хохирогчийг буруутгах аливаа хандлагыг илчилж, буруушаах чадвартай байх нь чухал.
- ✓ **Эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөх гол шалтгаан нь ядуурал, зөрчил юм:** Ядуу нөхцөлд амьдардаг хэдий ч хүчирхийлэл үйлддэггүй маш олон эр хүн бий. Эсрэгээрээ эмэгтэйчүүдийг хүчирхийлдэг баян эрчүүд маш олон. Зарим судлаач хүчирхийллийг ядуурлаас үүдэлтэй гэж үздэг ч, жендэрт суурилсан хүчирхийлэл нь хүч, эрх мэдлийн тэнцвэргүй байдлаас үүдэн гардаг.
- ✓ **Эмэгтэйчүүд санхүү мөнгөний ашиг сонирхлын үүднээс хүчирхийллийн тухай худал мэдээлдэг:** Худал мэдээллээс илүүтэй ийм төрлийн хүчирхийллийн тухай ярих, мэдээлэх явдал амьдралд эрс цөөн байдаг гол асуудал оршино. Хөгжиж буй оронд хохирогчдын дөнгөж долоон хувь нь л хүчирхийлэлд өртсөн тухайгаа мэдээлдэг аж. Ихэнх нь орон гэргүй болох, нөхөртөө хаягдах, хүүхдээ асран хамгаалах эрхээ алдахаас айж хүчирхийлэлд өртсөнөө мэдээлдэггүй байна.

Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг сурвалжилж, бичихэд анхаарах зүйлс:

- ✓ Үнэлж дүгнэсэн үг хэллэг ашиглахаас зайлсхий. Хохирогчийн түүх, түүний бэлгийн хандлага, харилцаа, өмнөх амьдрал, тухайн үед өмсөж байсан хувцас, байсан газар, хийж байсан зүйл, хэдэн цагийн үед бэлгийн хүчирхийлэл өртсөн зэрэгт хэт анхаарал хандуулах нь хохирогчийг буруутгах хандлагыг илэрхийлж болзошгүй. Зарчмын хувьд жендэрт суурилсан хүчирхийллийн тухай бичихдээ дээр дурдсан нөхцөл байдлын тухай мэдээлэхээс зайлсхийх нь зүйтэй. Мөн жендэрт суурилсан хүчирхийллийг соёл, уламжлалын нэг хэсэг, энгийн зүйл мэтээр харуулах нь бий. Тухайн үйл явдалтай шууд холбоотой биш л бол хохирогч болон холбогдогчийн үндэс угсааг дурьдах шаардлагагүй. Хүчингийн хэрэг, бэлгийн дарамтыг “гэгдэх”, “болсон гэх” зэргээр, өөрөөр хэлбэл болж өнгөрсөн нь эргэлзээтэй байдлаар бичиж, нийтлэхгүй байх хэрэгтэй. Мөн хохирогчийг “буруутан” байдлаар харуулах нь хүчирхийллийг зөвтгөх, мөн хүчирхийлэгчийг хаацайлах боломжийг олгон, болж өнгөрсөн үйл явдалд эргэлзэх хандлагыг бий болгохоос гадна тогтсон буруу хэвшмэл ойлголтыг дэмжих боломж олгодог.
- ✓ Хохирогчийг эрсдэлд оруулах, түүний нөхцөл байдлыг дордуулах нарийн мэдээллийг бүү дэлгэ. Тухайлбал бүтэн нэр, зураг, гэр бүлийн гишүүд, зарим үед хохирогчид туслалцаа үзүүлсэн хүмүүсийн нэрсийг дурьдахаас зайлсхийх хэрэгтэй. Түүнчлэн болсон үйл явдлын тухай онцлог зүйл, хохирогчийн болон түүнд туслалцаа үзүүлж буй этгээдийн гаднах байдлын тухай мэдээлэл нь тэднийг эрсдэлд оруулж болзошгүй.
- ✓ Нөхцөл байдлын талаар сайн мэдэж буй мэргэжилтнээс зөвлөгөө ав. Мэргэжилтний тайлбар нь тухайн нөхцөл байдлыг илүү сайн ойлгох, шаардлагатай нэмэлт мэдээлэл олж авахад тустай. Тэд хохирогчдыг хамгаалахын зэрэгцээ сэтгүүлчдэд мэдээлэл, тайлбарыг тэнцвэртэй өгөх мэдлэг, туршлагатай байдаг. Ялангуяа хохирогчийн эрхийг зөрчихгүйгээр, тэдэнд

болон гэр бүлд нь эрсдэл учруулахгүйгээр болсон явдлыг үнэн бодитоор мэдээлэх, эргэлзээтэй нөхцөл байдалд хэрхэх тухай энэ салбарын мэргэжилтнүүд илүү сайн мэдэж, зөвлөгөө өгдөг.

- ✓ Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг ажилладаг, хохирогчдод дэмжлэг үзүүлдэг орон нутгийн байгууллагуудын зөвшөөрлөөр тэдэнтэй холбоо барих мэдээллийг нийтэлж, ижил төстэй нөхцөлд байгаа, хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй бусад хүмүүст туслалцаа авах боломжийг олгох нь зүйтэй. Гэвч ийм үйлчилгээ үзүүлдэг байгууллага, газрын хаяг байршлыг нийтэлж, дүрсийг нь харуулахаас татгалзаж, харин холбогдох утсыг илүүтэй сурталчилна. Учир нь хохирогчдод үйлчилгээ, тусламж үзүүлдэг байгууллага руу хүчирхийлэгчид дайрах, дарамтлах тохиолдол гардаг тул энэ нь хохирогч болон үйлчилгээ үзүүлэгчдийн аюулгүй байдалд эрсдэлтэй.
- ✓ Хохирогчтой ярилцахдаа ёс зүйн болон аюулгүйн дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - Мэдрэмжтэй мэдээлэх, харилцах /хохирогчтой ярилцахдаа түүний нөхцөл байдлыг харгалзах, тухайлбал, эмэгтэй хохирогчтой эмэгтэй сэтгүүлч, эсвэл орчуулагч харьцах нь зохимжтой, орчуулагч шаардлагатай байх тохиолдолд мэдээллийн нууцыг хадгалах тухай орчуулагчтай заавал тохиролцоно/
 - Аюулгүй бөгөөд найдвартай, хувийн яриа өрнүүлэх боломжтой газрыг сонгох /ярилцагчийг нэмэлт дарамтад оруулах, хүчирхийлэлд өртөх эрсдлийг улам нэмэгдүүлэхээс зайлсхийхийн тулд шаардлагатай бүхнийг хийх, тухайлбал хохирогчийн нэр хүндийг унагах, гэр бүл, хамаатан садан, ойр дотны хүмүүсийн харилцааг муутгах эрсдэл зэргийг бодолцох/

- Хохирогчид хүндэтгэлтэй хандах /сэтгүүлч хүний хувьд хохирогчийн хувийн орон зайг хүндэтгэх, нийтлэл, нэвтрүүлэгт оруулахыг төлөвлөж буй мэдээлэл, асуудлыг дэлгэрэнгүй тайлбарлаж, тухайн хүнээс авсан мэдээллийг хэрхэн ашиглахаа ойлгуулж, тохиролцох, ярилцаж эхлэхээс өмнө ярилцагч бүх асуултанд хариулах албагүй, хүссэн үедээ завсарлах, тайвшрах, хариулахаас татгалзах эрхтэйг тайлбарлаж өгөх, мөн ярилцах явцдаа хохирогчийг буруутгасан хандлага бүхий асуулт тавихаас болгоомжлох/
- Өөрийн утас, холбоо барих мэдээллийг үлдээж, хүссэн үедээ холбогдох боломжтойг ойлгуулах, зан заншил, уламжлал, соёлын үнэт зүйлд бүдүүлгээр халдах, нэг болон хэсэг хүнийг аюулд учруулах, эвгүй байдалд оруулах, зовлон шаналал, уй гашууг өдөөх асуулт, хандлага, үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх/
- Ярилцах газраа сонгохдоо хохирогчид ямар нэгэн дарамт учрахааргүй, тайван ярих боломжтой байдлыг харгалзах, яриаг дэргэдээс хэн нэгэн сонсох боломжтой эсэхийг анхаарах, ярилцагч өөрийн дотны итгэлтэй хүн, өмгөөлөн хамгаалах хэн нэгэнтэй хамт байлцахыг зөвшөөрөх, ярилцах цаг, газрын талаар хохирогчийн саналыг асуух, тэрээр магадгүй гэрийнхэндээ юм уу хүчирхийлэгчид мэдэгдэлгүй гарч ярилцлага өгөх боломжтой цаг, газраа илүү сайн мэднэ/
- Гэр бүлийн хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой зураг дүрс, бичлэг ашиглах нь төвөгтэй тул хохирогч өөрөө сайн дураараа зөвшөөрснөөс бусад тохиолдолд хэн нэгний болон холбогдох орчны танигдахуйц зураг дүрсийг ашиглахаас цээрлэх (ашиглаж буй ямар ч дүрс, тухайн хүний нэр хүндийг сэвтүүлэхгүй байх буюу хамгаалах ёстой, боломжтой бол хүчирхийллийн тодорхой агшин бус, ерөнхий нөхцөл байдлыг харуулсан зураг дүрсийг ашиглах, хохирогчийн

зургийг авахаас зайлсхийх, зураг авсан тохиолдолд хохирогчоос бичгээр зөвшөөрөл авахаас гадна зураг авсан хүнтэй холбоо тогтоох боломжтой байх, зургийг сонгох, ямар байдлаар ашиглахыг зөвшилцөх эрх нь хохирогчид нээлттэй байх, бэлгийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй хүн, хүүхдийн зургийг хэзээ ч ашиглах ёсгүй).

- Хэвшмэл хандлагыг бэхжүүлэх зураг, дүрснээс татгалзахыг хичээ. Нулимс, хөх няц болсон бие, нүүр царай, цус, шарх зэргээр хүчирхийлэлд өртсөн эмэгтэйг дүрслэх хэвшмэл хандлага сэтгүүлчдийн дунд зонхилдог. Энэ нь ямар нэг байдлаар дуулиан дэгдээх, хүчирхийлэлд өртсөн хүнийг өрөвдөлтэй байдалд харуулахаас илүү үр дүнд хүрдэггүй бөгөөд харин ч ахин дахин ийм зураг дүрсийг үзүүлснээр үзэгч, сонсогчдыг хүчирхийллийн үйлдэлд дасахад хүргэдэг. Хохирогчийн зовлон шаналалыг бүү ашигла, тэдний хувийн орон зайг хүндэлж, нийгмийн ижил тэгш гишүүн, хувь хүн талаас нь харуулах, зөвхөн нийтлэхийг зөвшөөрсөн зураг, дүрсийг олны өмнө дэлгэх нь зүйтэй.
- Жендэрт суурилсан хүчирхийлэл нь эрх мэдэл, хүчний тэгш бус байдлаас үүдэлтэй бөгөөд энэ нь давуу байдлаа ашиглан үйлддэг хүний ёсноос гадуур бурангуй үйлдэл юм. Тиймээс энэхүү эрх мэдлийн харилцааг сэтгүүлч хүн давтаж, хохирогчид ямар ч сонголт үлдээлгүйгээр түүний тухай нийтэд дэлгэх нь ёс зүйгүй явдал юм. Хүчирхийлэлд өртсөн хүн тухайн хэрэг, нөхцөл байдал, өөрийнхөө тухай хэр их ярих эсэхээ өөрөө шийдэх эрхтэй. Энэ талаар ярих бүрт хохирогч сэтгэл зүйн дарамтад орж, хямардаг. Нөгөө талаас хүчирхийлэлд хэн ч өртөж болох учраас хохирогчийг “хүчирхийллийн золиос” гэхээс илүү нийгэм, гэр бүл, ойр дотныхондоо байр суурь эзэлсэн, туршлагатай, өөрийн гэсэн ертөнцтэй хувь хүн талаас нь харуулах нь мэргэжлийн сэтгүүл зүйн зарчимд нийцнэ.

- Хүчирхийлэлд өртсөн хүмүүс, хохирогч, тэдний ойр дотныхонд анхаарал хандуулж ярилцах нь буруу биш боловч ингэхдээ хүчирхийллийн асуудлыг өргөн хүрээнд харуулах, нөхцөл байдал, уялдаа холбоогтодруулж чадсан эсэхээ байнга нягтлах хэрэгтэй. Зөвхөн хохирогчийн тухай бичиж, нийтлэх нь асуудлыг явцууруулах, дуулиан болгоод өнгөрөх эрсдэлтэй. Тиймээс хариуцлагатай сэтгүүлч, хариуцлагатай редакцийн хувьд гол анхаарлыг хохирогчид хандуулахаас илүүтэй жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэх боломж, нөхцөл байдал, учир шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлийн талаар тодруулж, түүнээс урьдчилан сэргийлэх боломж, арга замыг харуулах үүрэгтэй. Нөгөө талаар энэхүү өргөн хүрээний нөхцөл байдлыг тодруулах өөр хэн байж болох талаар эргэцүүлвээс, сэтгэл зүйч, жендэрийн мэргэжилтэн, гэр бүл судлаач, өмгөөлөгч зэрэг хангалттай мэдээлэл өгч чадах олон эх сурвалж байгааг олж болно. Тиймээс, жендэрт суурилсан хүчирхийллийн тухай бүтээл заавал анхдагч эх сурвалжийн ярианд үндэслэх албагүй гэдгийг санаарай.

Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсөд, тэдний ойр дотны хүмүүсийн эрхийг хамгаалсан тохиолдол, эсвэл тэд хүчирхийллийг сөрж босч, амжилттай даван туулсан эерэг жишээг олон нийтэд түгээх онцгой эрх үүргийг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага хүлээдэг.

